



МОНГОЛ ҮНДЭСНИЙ БӨХИЙН ГАРАА ДЭВЭЭ, ШАВАА

БАГШ Д. БАТБАЯР

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ БӨХИЙН ГАРАА, ДЭВЭЭ ШАВААГ ТАНИН МЭДЭЖ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ

- *Үндэсний бөхийн гараа, дэвээ шавааг танин мэдэх, ойлгох*
- *Бусдадаа зааж сургах*
- *Хамтран ажиллах чадвартай болох*
- *Үндэсний бөхийн шинэ мэдлэгтэй болох*

ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААН НЬ
ОЛОН ЗУУН ЖИЛИЙН ТҮҮХЭН
УЛАМЖЛАЛТАЙ БА ЭРТ ДЭЭР ҮЕЭС ӨДИЙ
ХҮРТЭЛ ӨВЛӨГДӨН ХӨГЖИЖ ИРСЭН ГҮН
ГҮНЗГИЙ ДЭГ ЖАЯГ БҮХИЙ ҮНДЭСНИЙ
СПОРТЫН ТӨРӨЛ НОМ.

Үндэсний бөхийн барилдаан нь
бүрдэн тогтсон бөгөөд үүнд:

1. Эхэн буюу гаралтын үе
2. Үндсэн болон барилдааны үе
3. Төгсгөл буюу оролтын үе



ГАРАА ДЭВЭЭ ШАВААНЫ ТУХАЙ

Монгол бөхчүүд эрт дээр үеэс Гарьд, Бүргэд, Шонхор зэрэг хүчит эрэмгий шувуудын шинжийг илтгэн барилдахын өмнө гараа, дэвэлтийг хийж ирсэн нь бөхчүүдийн эр бяр, сүр хүчийг харуулахын зэрэгцээ бие халаалт нь болж өгдөг байна.



БӨХЧҮҮД БАРИЛДАХААР ГАРАХДАА

Бөхчүүд барилдахаар талбай буюу зүлэг ногоон дэвжээнд гарахдаа баруун, зүүн талд байгаа засуулуудад цолныхоо эрэмбээр ээлжлэн гарна. Ингэхдээ үнэн хүчийг үзэж барилдъя хэмээн гуяныхаа өвөр талд 2 удаа ар талд 1 удаа алгадан гарна. Энэ алгадах учир шалтгаан нь морь, бөх, сур гэсэн эрийн гурван наадмыг илтгэж байгаа болно.



ҮНДЭСНИЙ БӨХИЙН ШАВАА

Бөхчүүд дэвэлтийнхээ төгсгөлд нар зөв эргээд 2 хөл дээр хагас сууж гараа алдлан баруун зүүн тал руугаа цээжээ хагас эргүүлэн өөрийн сурсан шаваагаа хийнэ. Шаваа нь нисээж ирэн шувуу буухдаа далавчаа хумьж байгааг дүрслэн гуяны дотор, гадна талд тус бүр 1 удаа алгадан учираа бөхийн зүг эргэнэ.



МОНГОЛ БӨХИЙН ТАХИМ ӨГӨХ, АВАХ ЁС

Монгол бөхийн барилдаанд давсан өвдөг шороодсон 2 бөхийн барилдаан дууссаныг илтгэж буй найрсаг ёслол юм. Учираа таарч барилдсан 2 бөх тахим өгч авалцахдаа унасан бөх нь элэг бүсээ тайлан давсан бөхийнхөө баруун суган доогуур гарч өгнө. Гэхдээ унасан бөх нь давсан бөхөөсөө өндөр цолтой бол баруун гараа өргөн, элэг бүсээ тайлан зогсох үед давсан бага цолтой бөх нь суган доогуур нь гарч тахимаа өгнө.



БӨХИЙН ЦОЛ

Манай эриний VIII зууны үеэс бөхийн цол гунишин үүсэж XIII-р зууны дунд үеэс одоогийн хэрэглэж буй начин, заан, арслан зэрэг араатан амьтаны нэрээр нэрлэж сүр жавланг харуулдаг байснаа 2004 оноос хойш дараах цолыг нэрлэж байна. Үүнд:

1. 5 давсан бөхөд- Улсын начин
2. 6 давсан бөхөд- Улсын харцага
3. 7 давсан бөхөд – Улсын заан
4. 8 давсан бөхөд– Улсын гарьд
5. 9 давсан бөхөд-- Улсын арслан
6. 10 давж түрүүлсэн бөхөд– Улсын аварга цол өгдөг.





©fb.com/ErdenebulganPhotographer

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА